БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

---

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БНА-2020/9/СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: Bayankhongor@audit.gov.mn<br>Баянхонгор хот<br>2020 он | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас:70442584 Цахим хаяг:munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цээням<br>Утас: 70442424 Цахим хаяг:tseenyama@ audit.gov.mn<br>Аудитор:Д.Энхтуяа<br>Утас:99449299 Цахим хаяг:tomoo_etuya@yahoo.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Агуулга

**Аудитын гэрчилгээ** .... 3

2.1. Оршил .... 5

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .... 5

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .... 6

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .... 6

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .... 6

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .... 6

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .... 7

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .... 7

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .... 8

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .... 9

2.13. Шилэн дансны мэдээлэл .... 9

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .... 9

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .... 10

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .... 11

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .... 11

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .... 12

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .... 14

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .... 16

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .... 17

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .... 19



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**Аудитын гэрчилгээ**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2020.02.27 № 1/271

танай ______ -ны № ______ -т

БАЯНБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Э. НАНДИНБИЛЭГ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянбулаг Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл,санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот A4\

005020222



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Аудитын тайлан

### 2.1. Оршил

Баянбулагсумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Сургуулийн захирал Э.Нандинбилэгт танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасаншийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэгаудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 20-наас 2020 оны 02 дугаар сарын 24–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймгийн "Глобал капитал Аудит " ХХК-ийн аудитор Д.Энхтуяа хариуцаж х эрэгжүүлэв.

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2019 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн 72 тоот дугаар бүхий албан бичгээр 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

**2.4. Байгууллагын зорилго,үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант хугацаанд Багш ажилтнуудын манлайллыгнэмэгдүүлэхэд анхаарч,ёс зүй, сахилгын зөрчилгүй хамт олон болох эрхэм зорилтыгдэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамддараах өөрчлөлт ороогүй байна.

**2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуульнь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ний Acolous программ хангамж ашигладаг байна.

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

**2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 28 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсонбөгөөд материаллаг байдлын суурьүзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайлангийн нийт зардлын дүнгсонгож, эрсдэлийн түвшинг "их" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 621458,4 мянган төгрөгөөс 2,0 хувиар тооцон 12429,2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 12499,2 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн шатанд сонгосон суурь, материаллаг байдлыг тооцох хувийг өөрчлөөгүйтэй холбоотой болно.

**2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 32295,2 мянган төгрөгөөр буюу 9,3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал,үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0,0 | 0,0 | 0 |
| Авлага | | | |
| Дуусаагүй үйлдвэрлэл | | | |
| Бараа материал | 47551,1 | 77983,7 | 30432,6 |
| Үндсэн хөрөнгө | 835259,7 | 805618,2 | -29641,5 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл | -190984,3 | -159480,2 | -31504,1 |
| **Нийт хөрөнгө** | 691826,5 | 724121,7 | 32295,2 |
| Өр төлбөр | 14,4 | | -14,4 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 691812,1 | 724121,7 | 32309,6 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 691826,5 | 724121,7 | 32295,2 |

Бараа материалын дансны үлдэгдэл 30432,6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 155934,3 мянган төгрөгийн худалдан авалт хийж, бусад эх үүсвэрээс 19067,0 мянган төгрөгийн бараа материал орлого авч 144568,7мянган төгрөгийн зарцуулалт гарснаас шалтгаалжээ.

Энэ нь тайлант онд бусад хангамжийн материал 29230,4 мянган төгрөгөөр худалдан авч зарцуулалт хийгдээгүйтэй холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд өмнөх онуудад худалдаж авсан ашиглалтгүй нөөцөлсөн бараа материал байхгүй байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 29641,5 мянган төгрөгөөр буурсаннь тайлант онд төсвийн хөрөнгөөр 15507,2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, ОНХС болон бусад эх үүсвэрээр 17398,0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 62546,7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж данснаас хассанаас шалтгаалжээ.

Үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө байхгүй, 62546,7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох шийдвэрийн дагуу акталсан байна.

Биет бус хөрөнгөнд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 724121,7 мянган төгрөг болж 32309,6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга гараагүй.

### 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар тайлант онд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө байхгүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулантусгай зориулалтын шилжүүлгээс 567713,4 мянган, орон нутгийн төсвөөс 55929,6 мянган, нийт 623643,0 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулахаар төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийг бүрэн авч зарцуулан төсвийн хэмнэлтийн 1940,7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төсөв батлагдаагүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 621702,3 мянган төгрөг буюу 99,7 хувьтай байна.

**Нэмэлт төсөв:**Тайлант онд нэмэлт санхүүжилтийн орлого байхгүй байна

### 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 28 эрсдэл тодорхойлж , гүйцэтгэлийн шатанд нийт 28 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2947,0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч төлбөрийн акт тогтоов. Үүнд :

**1.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл**


005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

***Илрүүлэлт***

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг анхан шатны баримтаас түүн горим хэрэгжүүлэх явцад сургуулийн захирлын 2019.11.22 ны 5/37 тоот тушаалаар цалингийн сангаас ажилтнуудад түлшний үнийг хөнгөлөлтөд 2947,0 мянган төгрөгийг олгосон нь "Төсвийн тухай хууль"-ийн 16 дугаар зүйлийн 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэснийг зөрчсөн байна..

***Эрсдэл:*** Батлагдсан төсөв хэтрэх, Төсвийн тухай хууль зөрчигдөх

***Шийдвэрлэсэн нь:*** Төлбөрийн акт тогтоов.

**2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

1. Засгийн газраас тогтоосон дотуур байрны хүүхдийн хоол, Үдийн цайны зардлын нормативыг баримталж байгаа эсэхийг хянах.

**2.13. Шилэн дансны мэдээлэл**

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасанмэдээллийг байршуулах үүрэгтэй.

2019 оны мэдээлэл оруулсан байдал дараах байдалтай байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 7 | | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 3 | 1 | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 36 | | |
| | Тухай бүр | 8 | 96 | 93 | 3 | |
| | Нийт | 27 | 151 | 143 | 4 | 2 |

Шилэн дансны тухай хуулийн 6.1т заасны дагуу 3.1.1, 3.1.2 т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ гэсэн заалтыг зөрчиж 4 мэдээ, мэдээлэл хугацаа хоцроосон байна. Энэ нь тухай бүр мэдээлэх цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний 1 дугаар сарын мэдээ,таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл 2,3, дугаар сарын мэдээ,бүгд 4 мэдээ 10 сард нэмэлт зааварчилгаа өгсний улмаас дахин засварлан өөрчлөлт оруулсны улмаас хугацаа хоцорч мэдээлсэн байна

**2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Баянбулаг сумынЕрөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтболон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөх асуудал байхгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 3.1.Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**СТ-1А**

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| ,Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **47,551,113.60** | **77,983,713.60** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 47,551,113.60 | 77,983,713.60 |
| **351** | **Түүхий эд материал** | 3,370,150.00 | 3,370,150.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,370,150.00 | 3,370,150.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 43,281,963.60 | 74,613,563.60 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 00.00 | 1,449,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 14,284,400.00 | 15,337,600.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 225,000.00 | 247,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 640,800.00 | 217,300.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 28,131,763.60 | 57,362,163.60 |
| 35600 | Мал амьтад | 899,000.00 | 00.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **644,275,423.51** | **646,138,008.71** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 644,275,423.51 | 646,138,008.71 |
| **392** | **Биет хөрөнгө** | 617,499,423.51 | 619,362,008.71 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 583,196,600.00 | 583,196,600.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -25,492,416.82 | -36,407,901.46 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 133,701,933.60 | 116,339,640.60 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -111,631,556.85 | -85,022,773.99 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 69,184,385.23 | 61,827,853.18 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -50,765,352.62 | -34,118,673.63 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 6,009,000.00 | 6,009,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -2,219,991.23 | -3,055,891.19 |
| 39217 | Ном | 15,516,822.20 | 10,594,155.20 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 26,776,000.00 | 26,776,000.00 |
| 39301 | Програм хангамж | 875,000.00 | 875,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -875,000.00 | -875,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 26,776,000.00 | 26,776,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **691,826,537.11** | **724,121,722.31** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **14,399.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 14,399.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 14,399.00 | 00.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 14,399.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **691,812,138.11** | **724,121,722.31** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 691,812,138.11 | 724,121,722.31 |
| 511 | /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 417,388,192.00 | 417,388,192.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 417,388,192.00 | 417,388,192.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -179,353,528.89 | -147,043,944.69 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -179,353,528.89 | -179,353,528.89 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 32,309,584.20 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 453,777,475.00 | 453,777,475.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **691,826,537.11** | **724,121,722.31** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**СТ-2А**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **467,363,188.00** | **661,467,000.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **8,806,100.00** | **11,449,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 8,806,100.00 | 11,449,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 8,806,100.00 | 11,449,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 500,000.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 8,306,100.00 | 11,449,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **5,678,988.00** | **82,304,600.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 452,878,100.00 | 567,713,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,387,600.00 | 26,375,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,387,600.00 | 26,375,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 55,929,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 55,929,600.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 4,291,388.00 | 00.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 4,291,388.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **487,370,270.13** | **621,458,356.80** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **487,370,270.13** | **620,559,356.80** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 458,337,271.13 | 600,438,256.80 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 288,494,507.00 | 383,821,768.00 |
| 210101 | Үндсэн цалин | 222,400,428.00 | 277,284,094.00 |
| 210102 | Нэмэгдэл | 28,268,690.00 | 19,733,768.00 |
| 210104 | Урамшуулал | 18,433,989.00 | 65,905,906.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 19,391,400.00 | 20,898,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 34,002,600.00 | 53,977,033.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,250,300.00 | 40,036,633.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,210,100.00 | 3,485,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,263,100.00 | 2,788,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 565,800.00 | 697,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,713,300.00 | 6,969,900.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 45,923,750.00 | 49,407,100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,415,500.00 | 3,631,968.00 |
| 210302 | Түлш, халаалт | 40,708,250.00 | 43,975,132.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,784,000.00 | 8,290,920.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 731,900.00 | 1,424,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,256,000.00 | 3,368,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 406,900.00 | 1,357,400.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 359,200.00 | 357,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,030,000.00 | 1,603,520.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 42,543,100.00 | 44,064,480.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 269,800.00 | 477,480.00 |
| 210502 | Хоол, хүнс | 41,489,800.00 | 42,477,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 783,500.00 | 1,109,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,782,300.00 | 26,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,782,300.00 | 26,500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 318,600.00 | 1,650,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 318,600.00 | 1,650,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 288,000.00 | 2,080,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 288,000.00 | 1,680,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 37,200,414.13 | 30,646,555.80 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,264,600.00 | 3,977,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,795,700.00 | 3,325,600.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 29,140,114.13 | 23,343,555.80 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 29,032,999.00 | 20,121,100.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 28,930,888.00 | 18,180,400.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 4,291,388.00 | 00.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 17,145,000.00 | 16,969,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 6,887,400.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 607,100.00 | 1,211,400.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 1,940,700.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 1,940,700.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 102,111.00 | 00.00 |


005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 102,111.00 | 00.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **899,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 899,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 00.00 | 899,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-20,007,082.13** | **40,008,643.20** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 7,699,059.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 7,699,059.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -7,699,059.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-20,007,082.13** | **32,309,584.20** |

### 3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **459,057,088.00** | **650,018,000.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **500,000.00** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 500,000.00 | 00.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 500,000.00 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 500,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **458,557,088.00** | **650,018,000.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 452,878,100.00 | 567,713,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,387,600.00 | 26,375,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,387,600.00 | 26,375,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 55,929,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 55,929,600.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 4,291,388.00 | 00.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 4,291,388.00 | 00.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **459,057,088.00** | **650,018,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **459,057,088.00** | **650,018,000.00** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **430,024,089.00** | **629,435,900.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 288,491,289.00 | 388,434,100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 222,477,210.00 | 288,430,555.00 |
| 210102 | Нэмэгдэл | 28,188,690.00 | 22,737,704.00 |
| 210104 | Урамшуулал | 18,433,989.00 | 56,167,841.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 19,391,400.00 | 21,098,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 33,948,000.00 | 49,379,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,250,300.00 | 35,438,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,210,100.00 | 3,485,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,263,100.00 | 2,788,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,060,800.00 | 697,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,163,700.00 | 6,969,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 45,410,100.00 | 49,429,600.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,415,500.00 | 3,415,500.00 |
| 210302 | Түлш, халаалт | 40,194,600.00 | 44,214,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,593,400.00 | 17,131,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 731,900.00 | 1,381,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,968,000.00 | 3,368,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 406,900.00 | 2,810,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 456,600.00 | 3,044,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,030,000.00 | 6,346,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 42,744,500.00 | 43,179,900.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 325,400.00 | 477,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 41,635,600.00 | 41,592,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 783,500.00 | 1,109,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,782,300.00 | 40,250,000.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 13,750,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,782,300.00 | 26,500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 318,600.00 | 1,650,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 318,600.00 | 1,650,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,675,600.00 | 27,096,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,675,600.00 | 26,696,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8,060,300.00 | 12,885,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,264,600.00 | 7,999,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,795,700.00 | 4,885,600.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **29,032,999.00** | **20,582,100.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 28,930,888.00 | 18,641,400.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 4,291,388.00 | 00.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 17,145,000.00 | 17,430,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 6,887,400.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 607,100.00 | 1,211,400.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 1,940,700.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 1,940,700.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 102,111.00 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 102,111.00 | 00.00 |

### 3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

## ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **417,388,192.00** | **453,777,475.00** | **-179,353,528.89** | 691,812,138.11 |
| D01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **417,388,192.00** | **453,777,475.00** | **-179,353,528.89** | 691,812,138.11 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **417,388,192.00** | **453,777,475.00** | **-179,353,528.89** | 691,812,138.11 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 32,309,584.20 | 32,309,584.20 |
| D09 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **417,388,192.00** | **453,777,475.00** | **-147,043,944.69** | 724,121,722.31 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| • | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 623,643,000.00 | 621,702,300.00 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 623,643,000.00 | 621,702,300.00 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 605,001,600.00 | 603,060,900.00 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 390,133,200.00 | 388,434,100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 291,050,500.00 | 288,430,555.00 |
| 210102 | Нэмэгдэл | 22,001,100.00 | 22,737,704.00 |
| 210104 | Урамшуулал | 56,183,600.00 | 56,167,841.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 20,898,000.00 | 21,098,000.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 49,379,100.00 | 49,379,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,438,700.00 | 35,438,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,485,300.00 | 3,485,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,788,200.00 | 2,788,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 697,000.00 | 697,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,969,900.00 | 6,969,900.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 49,429,600.00 | 49,429,600.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,415,500.00 | 3,415,500.00 |
| 210302 | Түлш, халаалт | 44,214,100.00 | 44,214,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 17,131,400.00 | 17,131,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,381,800.00 | 1,381,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,368,000.00 | 3,368,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,810,600.00 | 2,810,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 3,044,400.00 | 3,044,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,346,600.00 | 6,346,600.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 43,331,300.00 | 43,179,900.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 477,300.00 | 477,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 41,744,100.00 | 41,592,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,109,900.00 | 1,109,900.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 40,250,000.00 | 40,250,000.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210602 | Тавилга | 13,750,000.00 | 13,750,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 26,500,000.00 | 26,500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,650,400.00 | 1,650,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,650,400.00 | 1,650,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 811,000.00 | 721,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 411,000.00 | 321,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12885600.00 | 12885400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,000,000.00 | 7,999,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,885,600.00 | 4,885,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 18641400.00 | 18641400.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 18,641,400.00 | 18,641,400.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 17,430,000.00 | 17,430,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,211,400.00 | 1,211,400.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 623,643,000.00 | 621,853,700.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 567,713,400.00 | 565,924,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 567,713,400.00 | 565,924,100.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 55,929,600.00 | 55,929,600.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 55,929,600.00 | 55,929,600.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 38 | 38 |
| 620001 | Удирдах ажилтан | 01 | 01 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 26 | 26 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 05 | 05 |
| 620004 | Гэрээт ажилтан | 06 | 06 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 291 | 281 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 291 | 281 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 291 | 281 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**НТ-2**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **26,375,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **26,375,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 26,375,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 26,375,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 26,375,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 26,375,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **26,375,000.00** |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 0.00 |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН: АУДИТОР Д.ЭНХТУЯА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ

ХОЁРДАХЬ ШАТАНД ХЯНАСАН: ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

Огноо: 2020.02.27



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ